



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/783

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "Аймгийн төсөв батлах тухай" 8/04 дүгээр тогтоол, Тэргүүлэгчдийн 2019 оны "Санхүүчдийг чадавхжуулах хөтөлбөр"-ийг баталсан 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дагуу бүртгэл, санхүү, эдийн засгийн ажилтнуудын тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний зардал 2225.0 мянган төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.


2. Тус арга хэмжээнд зарцуулах 2225.0 мянган төгрөг /хоёр сая хоёр зуун хорин таван мянган/-ийг аймгийн Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 5.8 дахь заалтын хөтөлбөрөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны 11 дүгээр
сарын 25-ны өдрийн А/783 дугаар
захирамжийн хавсралт



АЙМГИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН АЖИЛТНУУДЫН ТЭМДЭГЛЭЛТ
ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

дд	Үзүүлэлт	Тоо	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Спортын арга хэмжээний шүүгчдийн зардал	5	50000.00	250000.00
2	Урлагийн шүүгчийн зардал	3	50000.00	150000.00
3	Урлагийн шагнал /1 байр-150.0, 2 байр-120.0, 3 дугаар байр 100.0/	3	370000.0	370000.00
4	Ахмадын хүндэтгэл	40	20000.00	800000.00
5	Урилга, хөтөлбөр хэвлүүлэх	175	1000.00	175000.00
6	Спортын тэргүүний багийн /цом/ шагнал	1	200000.00	200000.00
7	Спорт, урлагийн медалийн үнэ	70	3500.00	245000.00
8	Өргөмжлөлийн үнэ	10	3500.00	35000.00
	Дүн			2225000.00

-oOo-